



# “БАЯНГОЛ ЗОЧИД БУУДАЛ” ХК ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

Огноо: 2022.03.17

Дугаар 05

Улаанбаатар хот

## Хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлан Хуралдуулах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 60.1, 62.1.1 болон 62.1.7 дахь заалт, Санхүүгийн Зохицуулах Хорооны 2018 оны 377 дугаар тогтоолоор баталсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”-ын 2.2 дахь заалтыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. “Баянгол зочид буудал” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2022 оны 04-р сарын 28-ны өдрийн 15 цагт цахимаар хуралдуулахаар товловсугай.
2. Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлаар дараах асуудлыг хэлэлцэхээр тогтоосугай. Үүнд:
  - 2.1. Компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэж батлах;
  - 2.2. ТУЗ-ийн гишүүдийг сонгох;
  - 2.3. Төлөөлөн удирдах зөвлөлийн төсвийг батлах;
  - 3.3. Ногдол ашиг хуваарилахгүй талаар ТУЗ-ийн шийдвэрийг танилцуулах.
3. Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2022 оны 4 сарын 8-ны өдрөөр тогтоосугай.
4. Хурлын мэдэгдлийг Санхүүгийн зохицуулах хороо МХБ-д хүргүүлэх өдрийг 2022 оны 03 дугаар сарын 21-ны өдрөөр, хувьцаа эзэмшигчдэд зарлах өдрийг 2022 оны 03 дугаар сарын 22, 2022 оны 4 дүгээр сарын 06-ны өдрүүд байхаар тогтоосугай.
5. Энэ тогтоолын 4-т заасан эхний өдөр буюу 2022 оны 03 дугаар сарын 21-ны өдрөөс Монголын Хөрөнгийн биржийн цахим хуудсанд байршуулах, 2022 оны 03 дугаар сарын 30-ны өдөр хувьцаа эзэмшигчдэд үйлчилдэг брокерийн компанид хүргүүлэх, 2022 оны 03 дугаар сарын 22 болон 4 дүгээр сарын 06-ны өдрүүдэд өдөр тутам хэвлэгдэн гардаг 2-оос доошгүй сонинд 2 удаагийн давтамжтай хэвлүүлэх, радио, телевизээр мэдээлэх зэргээр хурлын зарыг хувьцаа эзэмшигчдэд мэдэгдэхийг Хурал зохион байгуулах комисст даалгасугай.
6. Дараах бичиг баримт хувьцаа эзэмшигчдэд үйлчилдэг брокер дилерийн компаниуд дээр бэлэн байлгаж, хувьцаа эзэмшигчдэд хурал хуралдахаас өмнө танилцуулах ажлыг зохион байгуулсугай.
  - 6.1. Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах тухай ТУЗ-ийн шийдвэрийн хуулбар;

6.2.Компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, түүнд аудитын компаниас болон ТУЗ-өөс өгсөн дүгнэлт;

6.3. ТУЗ-д нэр дэвшигчдийн танилцуулга

6.4. Төлөөлөн удирдах зөвлөлийн төсвийн төсөл;

6.5. Ногдол ашгийн талаар ТУЗ-ийн шийдвэрийн танилцуулга

6.6. Хурлын зар

8. Хурлын санал хураах хуудасны загварыг энэхүү шийдвэрийн Хавсралт №1-ээр Цахимаар санал авах журмыг Хавсралт № 2-оор танилцах бичиг баримтын жагсаалтыг Хавсралт №3-оор тус тус баталсугай.

9. Санал хураах хуудсыг хүлээн авах эцсийн хугацааг 2022 оны 4 дүгээр 28-ны өдрийн 15 цагаар тогтоосугай.

10. Хувьцаа эзэмшигчдийн саналыг нэгтгэн шийдвэр гаргах ажиллагааг удирдан зохион байгуулахыг ТУЗ-ийн дарга /Б.Аюуш/-д даалгасугай.

11. Саналын хуудсыг хүлээн авах, тоолох тооллогын комиссыг дараах бүрэлдэхүүнтэй сонгосугай. Үүнд:

Дарга: Д.Самданжамц

Гишүүд: Т.Дөлгөөн, Д.Цэцэгмаа

11. Цахим хурлыг зохион байгуулах комиссын даргаар З.Цэрэнчимэгийг томилсугай.

12. Цахимаар хэлэлцүүлэх асуудалтай холбоотой танилцуулга, төсөл, гарах шийдвэрийн төслийг тогтоосон хугацаанд бэлэн болгож, хувьцаа эзэмшигчдэд танилцуулах ажлыг энэхүү тогтоолын 2-р хавсралтаар баталсан журмын дагуу зохион байгуулахыг Хурал зохион байгуулах комисс /З.Цэрэнчимэг/-д даалгасугай.



Б.АЮУШ